

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чулуунхороот сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/009/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат Бус Аудиторын Дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.24 № 422

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Д.НАРАНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Чулуунхороот сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011002019

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Чулуунхороот сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит Хийсэн Санхүүгийн Нэгтгэсэн Тайлан, Төсвийн Гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|----------|--|-----------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 653,609.20 | 612,832.80 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 297,870.30 | 261,759.50 |
| 33 | АВЛАГА | 147,274.20 | 98,343.90 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 208,464.70 | 252,729.40 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,744,132.80 | 4,797,149.30 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,744,132.80 | 4,797,149.30 |
| 39200 | Биет хөрөнгө | 4,729,453.70 | 4,714,161.60 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 14,679.10 | 82,987.70 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 5,397,742.00 | 5,409,982.20 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 115,737.90 | 62.7 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 115,737.90 | 62.7 |
| 41300 | Өглөг | 115,737.90 | 62.7 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,282,004.10 | 5,409,919.50 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,282,004.10 | 5,409,919.50 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 647,471.50 | 790,348.20 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 4,339,273.40 | 4,324,312.10 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 295,259.20 | 295,259.20 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,397,742.00 | 5,409,982.20 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-----------|---|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 7,520,009.20 | 2,501,293.90 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 262,280.50 | 429,245.60 |
| 110 | Орлогын албан татвар | 166,018.90 | 343,722.80 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 172,989.10 | 377,942.10 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -6,970.20 | -34,219.30 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 61,028.80 | 60,621.40 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 35,232.80 | 24,901.40 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,099,887.80 | 300,413.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,099,887.80 | 300,413.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,157,841.00 | 1,771,635.30 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,914,456.00 | 1,909,757.30 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,914,456.00 | 1,909,757.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,716,531.20 | 1,842,709.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 475,140.20 | 778,448.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,721.30 | 99,167.30 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,251.40 | 492,514.20 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 57,685.00 | 66,634.20 |
| 2105 | Нормативт зардал | 0 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,720.70 | 12,347.90 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,146.10 | 14,241.20 |

Чулуунхороот сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|------------|--|---------------------|-------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 557,460.00 | 44,449.90 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 522,406.60 | 334,905.40 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,197,924.80 | 67,048.30 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 4,605,553.30 | 591,536.60 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,424,434.70 | 617,260.90 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 3,181,118.60 | -25,724.30 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|-----------|--|--|------------------------|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,100,885.60 | 2,100,885.60 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,100,885.60 | 2,100,885.60 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 3,181,118.60 | 3,181,118.60 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,282,004.10 | 5,282,004.10 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 5,282,004.10 | 5,282,004.10 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,282,004.10 | 5,282,004.10 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 153,639.60 | 153,639.60 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -25,724.30 | -25,724.30 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 5,409,919.50 | 5,409,919.50 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-----------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 3,530,541.30 | 2,264,070.90 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 262,280.50 | 429,245.60 |
| 110 | Орлогын албан татвар | 166,018.90 | 343,722.80 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 172,989.10 | 377,942.10 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -6,970.20 | -34,219.30 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 61,028.80 | 60,621.40 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 35,232.80 | 24,901.40 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 821.6 | 1,378.70 |
| 1181 | Газрын төлбөр | 34,411.20 | 23,522.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 110,419.80 | 63,189.90 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 110,419.80 | 63,189.90 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,157,841.00 | 1,771,635.30 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,588,531.60 | 1,602,821.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,588,531.60 | 1,602,821.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,390,606.90 | 1,535,773.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 520,624.60 | 787,544.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,185.20 | 101,869.90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 32,400.40 | 493,534.90 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 53,438.60 | 48,252.20 |
| 2105 | Нормативт зардал | 0 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,999.70 | 16,992.90 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,146.10 | 14,241.20 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 494,947.70 | 10,768.40 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 210,864.60 | 62,569.30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,197,924.80 | 67,048.30 |

Чулуунхороот сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|------|---|---------------|-------------|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 942,009.60 | 661,249.20 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 1,000,398.00 | 697,360.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,000,398.00 | 697,360.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,000,398.00 | 697,360.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | -1,000,398.00 | -697,360.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | -58,388.40 | -36,110.80 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 356,258.70 | 297,870.30 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 297,870.30 | 261,759.50 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл |
|------|---|-------------|-------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,246,041.5 | 2,212,191.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,549,154.7 | 1,534,831.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,482,106.4 | 1,467,783.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 777,780.1 | 776,688.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 105,130.4 | 99,104.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 493,031.2 | 492,514.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 45,799.7 | 42,021.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,013.7 | 16,992.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 14,750.8 | 14,241.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,206.1 | 6,808.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,394.4 | 19,411.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 67,048.3 | 67,048.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 67,048.3 | 67,048.3 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 696,886.8 | 677,360.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,246,041.5 | 2,146,788.8 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,074,683.5 | 2,092,163.3 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 171,358.0 | 54,625.5 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 208,519.6 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 143,117.2 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|------|-----------------------------------|-----------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 64,532.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 64,532.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 44,532.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 425.2 |
| 2102 | Хангамж, бараа материалын зардал | 948.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,158.0 |
| 213 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,000.0 |
| 2132 | Дотоод эх үүсвэрээс | 20,000.0 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 64,532.1 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 64,532.1 |

Гурав. Аудитын Илрүүлэлт

Аудитаар илэрсэн 79.0 сая төгрөгийн 1 зөрчил¹ илэрсэнд зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Илрүүлэлт

Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл 79.0 сая төгрөг болон авлагын үлдэгдэл 144.2 сая төгрөгөөс тайлант онд төлөгдөх хөрөнгийн эх үүсвэр байхад төсөл сонгон шалгаруулж, зээл олгох ажил төлөвлөөгүй байна. Ингэснээр Хоршоо хөгжүүлэх санд "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д заасан "Сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах" зорилгоо хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгөөгүй байна. Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг бүрэн тооцоолж, зээл олгох ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дөрөв. Аудитаар Илэрсэн Буруу Илэрхийллийн Нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /сая төгрөгөөр/ | | | | | | | | | | | |
|-------------------------------|-------------|-------------|-----------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-------------|---|-----|-----|--|
| | | | Үүнээс | | | | | | | | | | | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | | |
| Тоо | | | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Зээл олгох ажлыг төлөвлөөгүй. | 1 | 79.0 | | | | | | | 1 | 79.0 | | | | |
| Дүн | 1 | 79.0 | | | | | | | 1 | 79.0 | | | | |

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.